



# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЭРМЭЛЗЭХ ЕСӨН ЗҮЙЛ



“Төрийн албаны шинэгэл: сорилт, боломж” Үндэсний анхдугаар чуулганад оролцогчид бид эх орондоо ардчилсан, сайн засаглалыг улам төлөвшүүлэн бэхжүүлж, нийгмийн хөгжлийн таатай нөхцлийг бурдүүлэн, тэр, иргэний итгэлцэлд тулгуурласан чанарлаг үйлчилгээг ард түмэндээ хүргэхийн төлөө төрийн нийт албан хаагчид дараах есөн зүйлийн шаардлагыг эрхэмлэн дагаж мөрдөхөөр хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

## **Нэг. Мэдлэгт сууринсан үйлчилгээ**

Хариуцсан ажлаа гүйцэтгэхэд хангалттай мэдлэгтэй байж, түүнийгээ цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн байнга хөгжүүлж, мэргэжлийн мэдлэг, ажил хэргийн нэгдлийн нягт хангаж ажиллана.

## **Хоёр. Чадварт сууринсан үйлчилгээ**

Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах ажлын зохистой арга барил, ур чадварыг зэмшиж, түүнийгээ ажлаа үр дунтэй, бүтээлтэй гүйцэтгэхэд чадамгай ашигладаг байна.

## **Гурав. Хууль ёсонд сууринсан үйлчилгээ**

Үндсэн хууль, бусад хуулийг үйл ажиллагаандаа дээдлэн сахиж, төрийн үйлчилгээг зөвхөн тэдгээрт нийцүүлэн хараат бус, бие даасан байдлаар хүргэж хэвшинэ.

## **Дөрөв. Ёс зүйд сууринсан үйлчилгээ**

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр төрийн албанд ажиллах бөгөөд ёс зүйн зарчим, хэм хэмжээ, ёс суртахууны шаардлагуудыг эрхэмлэн биелүүлж, ёс зүйн аливаа зөрчил гаргахгүй ажиллана.

## **Тав. Шударга ёсонд сууринсан үйлчилгээ**

Албаны үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахдаа алагчлахгүй, тал тохой татахгүй, ямарваа хөндлөнгийн нөлөөлэлд орохгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилд автахгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлж шударга ёсыг баримтална.

## **Зургаа. Соболтой харилцаанд сууринсан үйлчилгээ**

Иргэдэд байнга хүндэтгэлтэй хандаж, тэдний итгэл хүндэтгэлийг олох хэмжээнд харилцааны соёлыг эзэмшиж зөлдэг, уриалга үйл ажиллагаа, үйлчилгээгээ нээлттэй, ил тод байлгаж, олон нийтийн санаа бодлыг авч, эрэлт хэрэгцээнд нь нийцэн үйлчилгээ үзүүлж ажиллана.

## **Доогoo. Үнэич байдалд сууринсан үйлчилгээ**

Төрийн албандaa ямагт чин сэргээсээ веериймсэг хандаж, түүнийг аль болох үр бүтээлтэй, илүү чанартай гүйцэтгэх талаар ононаачлага, идэвх зүтгэл гарган, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэх талаар боломжтой бүх нөөц бололцоог дүүрэн ашиглаж ажиллана.

## **Найм. Шуурхай байдалд сууринсан үйлчилгээ**

Албаны үйл ажиллагааг явуулахдаа бусдад злдэв чирэгдэл учруулахгүй байж, ялангуяа иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтэнд нэн анхааралтай хандаж, хариуг боломжтой хамгийн бага хугацаанд өгөх хэмжээнд ажлаа зохион байгуулна.

## **Ес. Хариуцлагад сууринсан үйлчилгээ**

Албаны ажил хэргийг явуулахдаа веересөө зайлцуулах, хариуцлагаас делех зэрэг аргацаах зохисгүй байдал гаргахгүй, ажилдаа эзэн болж, шийдэмгий зоримог ажиллан, түүнийхээ үр дунг биечлэн хариуцаж ажиллана.

“Төрийн албаны шинэгэл: сорилт, сургамж” Үндэсний чуулганад оролцогчид

2011.06.23

Эрмэлзэх есөн зүйлийг дэмжин хулзэн авсан